



БАЯНХОНГОР АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ХУРЛЫН ТОГТООЛ

2018 оны 03 сарын 03 өдөр

Дугаар 25

Номгон

“Спейшл майнз” ХХК-ний үйл ажиллагаанд
хяналт шалгалт хийх ажлын хэсэг
томилох тухай

Монгол улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.4, 20.1.7, 20.1.11, 22 дугаар зүйлийн 22.1.9 дэх заалтуудыг тус тус үндэслэн аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. “Спейшл майнз” ХХК-ний үйл ажиллагаанд хяналт шалгалт хийх, дүгнэлт гаргаж танилцуулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүтэй томилсугай.

Ахлагч: Ц.Отгонбаяр – Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын дарга
Гишүүд: Ж.Хүрэлбаатар – Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын төлөөлөгч,
Тэргүүлэгч

С.Готов – Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын төлөөлөгч, Тэргүүлэгч

Ц.Төмөрбаатар – Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын төлөөлөгч, Тэргүүлэгч

Д.Ганбаатар – Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын төлөөлөгч, Тэргүүлэгч

Б.Оюутболд – Аймгийн Цагдаагийн газрын дарга

Н.Бямбадорж – Аймгийн Мэргэжлийн хяналтын газрын дарга

Б.Бат-Өлзий – Аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газрын дарга

Д.Дэлгэрсайхан – Хэвлэлийн төлөөлөгч

2. Ажлын хэсгийн ажиллах удирдамжийг хавсралтаар баталсугай.

3. Ажлын хэсгийн дүгнэлтийг 2018 оны 04 дүгээр сарын 15-ны дотор аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн хуралдаанд танилцуулахыг ажлын хэсэгт даалгасугай.

ДАРГА

Ц.ОТГОНБАЯР



0117321

Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын
Тэргүүлэгчдийн 2018 оны 03 дугаар сарын
03-ны өдрийн 25 дугаар тогтоолын хавсралт



“СПЕЙШЛ МАЙНЗ” ХХК-НИЙ ҮЙЛ АЖИЛЛАГААНД
ХЯНАЛТ, ШАЛГАЛТ ХИЙХ АЖЛЫН ХЭСГИЙН
АЖИЛЛАХ УДИРДАМЖ

НЭГ. ШАЛГАЛТЫН ЗОРИЛГО

Баян-Овоо суманд ашигт малтмалын ашиглалтын үйл ажиллагаа явуулж буй Спейшл майнз ХХК-ний үйл ажиллагаатай газар дээр нь танилцаж, Газрын хэвлийн тухай хууль, Байгаль орчныг хамгаалах тухай хууль, Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль, Ашигт малтмалын тухай хууль, Уулын ажлын төлөвлөгөөний хэрэгжилт, иргэд олон нийтийн дунд гарсан гомдол, мэдээллийг хянаж, хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, химийн хорт бодис ашиглах, тэсэлгээ хийх журам зааврыг мөрдөж ажиллах байгаа эсэх, иргэд хордсон болон байгаль орчин бохирдсон талаар үнэлэлт, дүгнэлт өгөхөд оршино.

ХОЁР. ШАЛГАЛТЫН ХАМРАХ ХҮРЭЭ

Баян-Овоо суманд ашигт малтмалын ашиглалтын үйл ажиллагаа явуулж буй Спейшл майнз ХХК-ний үйл ажиллагаа

ГУРАВ. ШАЛГАЛТ ХИЙГДЭХ ХУГАЦАА

Шалгалтыг 2018 оны 04 дүгээр сарын 02-ны өдөр зохион байгуулна.

ДӨРӨВ. ШАЛГАЛТЫН БҮРЭЛДЭХҮҮН

Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын даргын захирамжаар томилогдсон ажлын хэсгийн бүрэлдэхүүн

ТАВ. ШАЛГАЛТЫН ҮР ДҮН

1. Спейшл майнз ХХК-ний үйл ажиллагаа хууль тогтоомжийн дагуу явагдаж байгаа эсэх, иргэд хордсон болон байгаль орчин бохирдсон талаар тогтоох
2. Компаний үйл ажиллагаатай холбоотой гарсан гомдол, мэдээллийн талаар дүгнэлт гаргах
3. Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, химийн хорт бодис ашиглах, тэсэлгээ хийх журам, зааврыг мөрдөж ажиллах байгаа эсэхэд үнэлэлт өгөх
4. Хяналт, шалгалтын үр дүнг 2018 оны 04 дүгээр сарын 15-ны дотор аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн хуралдаанд танилцуулна.